

2021.3.1-ний өдрөөс мөрдөгдөх чангаруулсан арга хэмжээ

БН Чех Улсын нутагт 2-р сарын 27 өдрөөс 3-р сарын 28 өдөр хүртэл **онцгой байдал** үргэлжлэн мөрдөгдөнө.

3-р сарын 27-ны өдөр хүртэл мөрдөгдөх чангаруулсан арга хэмжээ

Өөр сумын нутаг руу зорчихыг хориглосон – Ажилдаа явах, эмчид үзүүлэх, албан байгууллагад ажил хөөцөлдөхөөр явах тохиолдолд энэ хориг хамаарахгүй. Энэ талаархи мэдээллийг дараах линкээр орж уншина уу: <https://covid.gov.cz/opatreni/pohyb-venku/narizeni-omezeni-pohybu>

15 дээш насны хүмүүс өөрийн амьдардаг сумын нутгаас гадагш зорчиход – эмчид үзүүлэхээр, албан байгууллагад очихоор явж байгаа тухай батламжилсан мэдэгдэл, ажил хийхээр явж байгааг тодорхойлох ажлын газрын бичиг, ажил хийлгэх захиалгын хуудас (хувиар хөдөлмөр эрхэлдэг бол батламжилсан мэдэгдэл бичнэ).

БӨГЛӨХ ШААРДЛАГАТАЙ ХҮСНЭГТ БОЛОН БАТЛАМЖ МЭДЭГДЛИЙН МАЯГТУУД:

Батламж мэдэгдэл: https://www.vlada.cz/assets/media-centrum/aktualne/Cestne_prohlaseni_vzor.docx

Тухайн сумын нутгаас гадагш явахад бөглөх маягт: https://www.vlada.cz/assets/media-centrum/aktualne/Formular_pro_cesty_mimo_okres_-_vzor.docx

Тухайн сумын нутгаас гадагш ажлаар явахад бөглөх маягт: https://www.vlada.cz/assets/media-centrum/aktualne/Potvrzeni_zamestnavatele_na_cesty_do_mista_vykonu_prace_-_vzor.docx

Дэлгүүрээс хүнс худалдаж авахдаа оршин суудаг сумын нутгаас гадагш явах хориотой. Хүсний дэлгүүр, эмийн сан, гоо сайхан ба ариун цэврийн барааны дэлгүүр, нүдний шилний газар, захиалсан бараа олгох цэгүүд ажиллана.

Хэрэв 2 газарт ээлжлэн амьдардаг бол 3 долоо хоногийн хугацаанд **аль нэг газрыг** нь сонгож амьдарна. Хоёр газарт ээлжилж амьдардаг гэр бүлийн хүмүүст бас хамааралтай.

Спорт, чөлөө цагаа өнгөрүүлэх тохиолдолд оршин суудаг сумын нутгаас гадагш явахыг хориглоно. Нохойгоо салхинд гаргахад өөрийн байрнаас 500 метрээс холдож болохгүй.

Найз нөхөд болон хамаатан садан танай хотод болон 1 сумын нутагт амьдардаг байсан ч гэрт нь зочилж очихыг хориглосон (эмчид үзүүлэх, албан байгууллагад дагаж очих зэрэгт хамт явах зайлшгүй шаардлагатай бол энэ хориг хамаарахгүй).

Эмнэлгийн ажилтнуудын хүүхэд явдаг цэцэрлэгүүдээс бусад сургууль, цэцэрлэгүүд ажиллахгүй.

Шөнийн цагаар хөл хорих шийдвэр хүчинтэй хэвээр (21:00 – 4:59 хооронд). Бусад хүнтэй харьцахдаа **2 метрийн** зайг барих шаардлагатай.

Респиратор/нано маск зүүх:

- Нийтийн тээврээр зорчиход, автобусны буудал дээр, хүлээлгийн зааланд, дэлгүүрт, үйлчилгээний газруудад, эмнэлгийн байранд, нийгмийн үйлчилгээ үзүүлэх газруудад, олон улсын нисэх буудалд
- 15 нас хүртэлх хүүхдүүдэд үл хамаарна
- **Респираторыг 2 давхар амны маскаар орлуулж БОЛОХГҮЙ**

Мэс заслын маск зүүх:

- Өөрийн амьдардаг байрнаас бусад барилга байшин дотор
- Ажлын байранд (ажлын өрөөнд ганцаар ажилладаг бол маск зүүх хэрэггүй)

- Хотоос гадагш байрлах гадаа талбайд 2 метрийн зайнд өөр хүн байхгүй тохиолдолд.

Дээр дурдсан хориг арга хэмжээний хэрэгжилтийг БНЧУ-ын Цагдаагийн байгууллага, цэргийн албан хаагчид хянаж ажиллана. Хориг арга хэмжээний талаархи мэдээллийг

**Э
Н
Д
Э
Э
С**

**У
Н
Ш
И
Н
А**

**У
У
:**

**Н
Ү
Р
Е
Р
Л
Л
И
Н
К**

**"
h
t
t
p
:
/
/
w
w
w
.
c
o
v
i
d
.
g
o
v
.
c**